



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/250

Чингис хот

Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.8, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдааны 2016 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.17 дахь заалтын хүрээнд “Эрүүл мэнд хөдөлгөөн-Хөгжил” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин, Баян-Овоо, Батноров Бэрх, Гурванбаян, Өлзийт сум, тосгоны иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад 5.183.000 /таван сая нэг зуун наян гурван мянга/ төгрөгийг зарцуулсугай.

2. Арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулж, удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010708